

**НИЙСЛЭЛИЙН АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН  
2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ӨРГӨДӨЛ,  
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Байгууллагын хэмжээнд 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 218 өргөдөл, гомдол ирснээс хугацаандаа шийдвэрлэж хариу өгсөн 187, хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн 23, судлагдаж байгаа 8 өргөдөл, гомдол байна. Захиргааны хэлтэст 39, Бодлогын хэрэгжилтийн хэлтэст 87, Агаарын чанар, хяналт, зохион байгуулалтын хэлтэст 89 өргөдөл, гомдол цохогдсон байна. Өргөдлүүдийн дамжин ирсэн эх үүсвэрүүд НҮНТ- 10 ,ННЗБ бүртгэсэн 30, 1800-1200 дугаараас ирсэн 101, 11-11 төвөөс ирсэн 61, E-Service 5, гар утаснаас 61, фэйсбүүк 6 нийт өргөдөл, гомдол 218 ирсэн байна. Мөн байгууллагад цаасаар ирсэн өргөдөл, гомдлыг скайнердаж egr.ulaanbaatar.mn-д оруулан байгууллагын удирдлагад шилжүүлэн ажиллаж байна.

Ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл 5 хоногт багтаан шийдвэрлэсэн 69, 10 хоногт багтаан шийдвэрлэсэн 41, 15 хоногт багтаан шийдвэрлэсэн 37, 30 хоногт багтаан шийдвэрлэсэн 40, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 23 өргөдөл байна. 2020 оны эцсийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 13 хоног 8 цаг 47 минут байна.

Хүснэгт 1. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал /Хэлтэс тус бүрээр/

Нэгж/хэлтэс	Хугацаандаа шийдвэрлэсэн	Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн	Шийдвэрлэх хугацаандаа байгаа
Захиргааны хэлтэс	34	3	2
Бодлогын хэрэгжилтийн хэлтэс	76	8	3
Агаарын чанар, хяналт, зохион байгуулалтын хэлтэс	76	12	1
Удирдлага	1	-	1
Нийт	187	23	7

Жилийн эцсийн байдлаар өргөдөл, гомдлын хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн, өргөдөл гомдлыг өдөрт нь хүлээж аваагүй, явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчлүүд их байна. Өргөдөл гомдлын хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн мэргэжилтэн, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн явцад хяналт тавьж ажилласан боловч тус байгууллагаас гадна байгууллагын өргөдлийг дамжуулах шийдвэрлэх хариуг хүлээх зэрэг шалтгаанаас болж хугацаа хэтрүүлэлт ихэссэн байна. Архив, бичиг хэргийн эрхлэгч нь байгууллагын албан хаагч нарт газрын шуурхай хурал болгон дээр бүх албан хаагч нарт сануулан, удирдлагын зүгээс анхааруулга өгсөн.

2021 онд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг 1 оронтой түүнд оруулан ажиллах, өргөдөл гомдлын шийдвэрлэлт дээр хатуу хяналт тавьж төлөвлөгөөний дагуу бүх албан хаагч нарт анхааруулан ажиллана.

ТАНИЛЦСАН:ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА

О.АЛТАНГЭРЭЛ

ТАЙЛАН ГАРГАСАН: АРХИВ, БИЧИГ  
ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ

Э.БЯМБАЦЭЦЭГ